

ХОРИХ БАЙГУУЛЛАГЫН ХАРУУЛ ХАМГААЛАЛТАД ТЕХНИК, ТЕХНОЛОГИЙН ДЭВШЛИЙГ АШИГЛАХ НЬ



Ч.МӨНХ-ЭРДЭНЭ

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Хорих ял эдлүүлэх албаны дэд дарга бөгөөд харуул хамгаалалт, аюулгүй байдлын хэлтсийн дарга, дэд хурандаа

Товч агуулга. Илтгэлийн хүрээнд Монгол Улсын хорих байгууллагын харуул хамгаалалтын үйл ажиллагаанд ашиглаж буй техник хэрэгслийн өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга замын талаар өөрийн санал дүгнэлтийг гаргахыг зорьсон.

Abstract. Presentation is aiming to share own views and opinion on the current state and challenges of security equipment and devices used in Mongolian correctional units and proposing solutions

Түлхүүр үгс. Хорих байгууллага, харуул хамгаалалт, хоригдол, биечилсэн хяналт, техникийн хяналт, техник хэрэгсэл, дуу-дүрсний бичлэг.

Keywords. Correctional unit, guard and security, inmates, direct supervision, technical supervision, equipment and devices, audio-video footage.

Монгол Улсын хорих байгууллага нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын хуулиар хүлээсэн үндсэн чиг үүргийн нэг болох яллагдагчийг цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх, хорих ял шийтгэгдсэн этгээдэд оногдуулсан ялыг албадан эдлүүлэх, тэднийг нийгэмшүүлэх, аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүргийг хэрэгжүүлдэг.

Монгол Улсын хэмжээнд 2018 онд үйлдэгдсэн нийт гэмт хэрэг 1968 он буюу 50 жилийн өмнөхтэй харьцуулахад 10 дахин, 2003 онтой харьцуулахад 1,8 дахин өссөн нь хорих ял шийтгэгдэгсдийг нийгэмшүүлэх, харуул хамгаалалтыг чанд зохион байгуулж, аюулгүй байдлыг хангах, давтан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг дээшлүүлэх шаардлагатайг харуулж байна.

Хорих байгууллагын харуул хамгаалалт, аюулгүй байдлын алба нь хоригдогч, хоригдлыг оргон зайлах, хорих ангийн хэвийн үйл ажиллагааг алдагдуулж болохуйцаар эмх замбараагүй байдал бий болгох, өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэндэд хохирол учруулах зэрэг гэмт үйлдлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чиг үүргийг хэрэгжүүлдэг.

Дээрх гэмт үйлдлээс урьдчилан сэргийлэх, тэмцэх, таслан зогсооход харуул хамгаалалт, аюулгүй байдлын үйл ажиллагааг хүний хүч, техник хэрэгслийг хослуулан зохион байгуулах нь үр дүнтэй байдаг.

Өнөөдөр Монгол Улсын хорих байгууллагын харуул хамгаалалтын үйл ажиллагааг гадна болон дотоодын хамгаалалт гэж ерөнхийд нь ангилан зохион байгуулж байна.

2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, түүнд нийцүүлэн баталсан “Хорих ангийн харуул хамгаалалтын журам”-д гадна хамгаалалтын инженерийн байгууламжийг гадна хориотой бүс, хамгаалалтын хашаа, дулаан, хөдөлгөөн мэдрэх дохиолол, цахилгаан хүчдэлийн шугам, дүрс бичлэгийн хяналт бүхий зурвас, нэвтрэх хэсгийн дуу-дүрсний бичлэгийн хяналт бүхий бүстэй байхаар тогтоож, гадна хориотой бүсийг хот суурин газарт хамгаалалтын хашаанаас гадагш 500 метр, орон нутагт 1000 метр зайд байхаар хуульчилсан.

Хорих ангиудын өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавих, болзошгүй эрсдлийн үед шуурхай удирдлагаар хангах зорилгоор Шуурхай удирдлага, хяналтын төвийг байгуулан хорих анги, байгууллагуудыг дүрсний бичлэг, дохиоллын нэгдсэн системд холбосон нь харуул хамгаалалтын удирдлага, зохион байгуулалтыг сайжруулахад чухал ач холбогдолтой болсон.

Өнөөдрийн байдлаар хоригдлын зүгээс үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн тоог судлан үзэхэд 2003 он буюу 15 жилийн өмнөх үеэс 20 дахин буурсан үзүүлэлтэй байна.

Энэ нь харуул хамгаалалтын үйл ажиллагаанд дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлж, ашиглалтыг сайжруулсантай холбоотой юм.

Харуул хамгаалалтын биечилсэн хяналт, хамгаалалтын ажилтны өдөр тутмын үйл ажиллагаа болон хамгаалалтад ашиглаж буй техник хэрэгсэлд тавих шалгуур үзүүлэлтийг нэгдсэн стандартад оруулснаар зохих үр дүнгээ өгч байгаа хэдий ч тодорхой хүндрэл бэрхшээл тулгарсаар байна.

Үүнээс зарим сорилт бэрхшээлийг тодорхойлбол, Монгол Улс нь 1.6 сая хавтгай дөрвөлжин километр буюу өргөн уудам газар нутагтай бөгөөд өнөөдрийн байдлаар улс орны технологийн хөгжлөөс шалтгаалан үүрэн холбоо, интернетийн хүрэлцээ, хурд тэр бүр хангалттай хэмжээнд хүрээгүй нь улс орны тодорхой газар нутагт байршиж буй хорих ангиудын харуул хамгаалалтын технологийн хөгжилд шууд нөлөөлж байна.

Түүнчлэн байгаль, цаг уурын эрс тэс уур амьсгал бүхий өвөрмөц нөхцөлд байдгаас харуул хамгаалалтад ашиглаж буй техник нь дулааны улиралд цөлсийн +30, хүйтний улиралд -40 хэмд ажиллах шаардлага тулгардаг нь техникийн ашиглалтад сөргөөр нөлөөлж, эвдрэл, гэмтэл дагуулдаг.

Мөн улсын хэмжээнд 2006 оныг 2018 онтой харьцуулахад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг 32 дахин, холбогдсон этгээдүүд 12 дахин өссөн ба дээрх төрлийн бодисыг хорих ангийн байршилд нэвтрүүлэх санаа зорилго бүхий оролдлого гарч эхэлсэн тул мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг таньж, илрүүлэх төхөөрөмжийг харуул хамгаалалтад нэвтрүүлэх зайлшгүй шаардлага урган гарч байгаа юм.

Бид өнөөдрийн байдлаар гадаадын зарим орны хорих байгууллагуудад хүндрэл учруулж буй хөдөлгөөнт утас хорих ангид нэвтрүүлэх, ашиглах зөрчилтэй тэмцэх зорилгоор сүлжээ унагаагч төхөөрөмжийг нийт хорих ангиудад нэвтрүүлэн хорих ангид хөдөлгөөнт утас хэрэглэх зөрчлийг таслан зогсоосон.

Энэ зөрчлийг таслан зогсооход хоригдлын эрх зүйн байдлыг дээшлүүлж, хоригдлын хувийн онцлог, засрал хүмүүжлийг нь харгалзан утсан харилцаагаар харилцах эрхийг нэмэгдүүлэх, зарим тохиолдолд урамшуулал хэлбэрээр олгодог болсон нь техник, технологийг эрх зүйн зохицуулалттай уялдуулан цогц байдлаар шийдвэрлэх арга замыг эрэлхийлсэнтэй холбон үзэж болно.

Гэвч дэлхий нийтэд өрнөж буй техник технологийн хурдацтай хөгжилд нийцүүлэн хорих ангийн харуул хамгаалалтад ашиглаж буй техник хэрэгслийг тухай бүр шинэчлэн сайжруулахад хүндрэлтэй байна.

Хорих ангийн харуул хамгаалалтын техникийг хариуцсан мэргэшсэн ажилтныг бэлтгэх тогтолцоог хөгжүүлэх, мэргэшсэн хүний нөөцийг бүрдүүлэх шаардлага ч урган гарч байна.

Харуул хамгаалалтын үйл ажиллагаанд техник технологийг ашиглах нь зайлшгүй боловч алба хаагчийн биечилсэн хамгаалалтын чанар, үр дүнг орхигдуулж болохгүй юм.

Харуул хамгаалалт нь “Биечилсэн хяналтад дэмжлэг үзүүлэх хэрэгсэл нь техник юм” гэсэн үндсэн агуулгын хүрээнд зохион байгуулагдах ба алба хаагчийн үйл ажиллагааг хөнгөвчлөх, туслалцаа үзүүлэхэд чиглэгдсэн байдлаар хийгдэх учиртай.

Монгол Улсын хорих байгууллагын харуул хамгаалалтын техник технологийн ашиглалт, тасралтгүй хөгжиж буй технологийн дэвшилтэй нийцүүлэхэд дараах асуудалд анхаарал хандуулан ажиллаж байна. Үүнд:

1.Хорих байгууллагын чиглэлээр мэргэшсэн техникийн ажилтнуудыг бэлтгэх, Монгол орны эрс тэс уур амьсгалд тохирсон техникийн шийдлийг бий болгоход чиглэсэн инновацийн бүтээгдэхүүнийг бий болгоход анхаарч, өөрийн улс орны техникийн сургалт, судалгааны байгууллагуудтай нягт хамтран ажиллах;

2.Хоригдогсдын бүртгэл, хяналтын нэгдсэн системийн үйл ажиллагааг байнга шинэчилэн, хөгжүүлэх;

3.Харуул хамгаалалтад ашиглаж буй техник хэрэгслийг хүний бие организмд хор нөлөөгүй, аюулгүй байдлын наад захын шаардлага хангасан байдлаар шийдвэрлэх зэрэг нь хорих байгууллагад үйлдэгдэж болзошгүй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чухал ач холбогдолтой гэж үзэж байна.